



ДУНДГОВЬ АЙМАГ
ЭРДЭНЭДАЛАЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 05 өдөр

Дугаар А/61

Сангиндалай

Зардал гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.8 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг зарцуулах, тайлагнах журмын 3.5.3, 3.6.16 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Өвөрмонголын өөртөө засах оронд уур амьсгалын өөрчлөлт, цөлжилтийг сааруулах туршлага судлах 5 хүний сургалтын төлбөр 10,400,000 (арван сая дөрвөн зуун мянган) төгрөгийг Байгаль орчныг хамгаалах сангаас зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Г.Энхдэлгэр), нягтлан бодогч (Ж.Хишигсүрэн) нарт зөвшөөрсүгэй.

2. Доройтсон бэлчээрийг сэргээх мод, сөөгийг тарьж ургуулах эдийн засгийн эргэлтэд оруулах туршлагыг судалж орон нутагт хэрэгжүүлж ажиллахыг сургалтад хамрагдаж буй хүмүүст үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ЛХАГВАМАНДАЛ

482302121